

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн
яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022
оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/516
дугаар тушаалын 2 дугаар хавсралт

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТЫН
ХӨТӨЛБӨР

НЭГ. ХӨТӨЛБӨРИЙГ БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ,
ШААРДЛАГА, ХАМРАХ ХҮРЭЭ:

1.1.Хэрэгцээ, шаардлага:

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үйл ажиллагааны эрхэм зорилго, зорилт, салбарын бодлогыг оновчтой тодорхойлж, хэрэгжүүлэхэд төрийн албан хаагчдаас мэдлэгээ байнга дээшлүүлэх, чадвартай мэргэшсэн албан хаагч байх цогц чадамжийг шаардаж байна.

“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 5.4-т заасан “Иргэндээ үйлчилдэг, мэргэшсэн, чадварлаг, ил тод, үр нөлөөтэй, ухаалаг төрийн албыг төлөвшүүлэх” зорилтын хүрээнд чадахуйн зарчимд суурилсан, мэргэшсэн төрийн алба төлөвшүүлэх, төрийн албан хаагч цаг хугацаа, орон зайнаас үр хамааран тасралтгүй сурч хөгжих таатай орчин бүрдүүлэх чиглэлээр төрийн байгууллага бүр ажиллах шаардлагатай болсон.

Хөтөлбөрийг шинэчлэн боловсруулахтай холбогдуулан хэрэгцээ, шаардлага тодорхойлох судалгааг албан хаагчдаас авсан бөгөөд судалгаанд нийт 65 албан хаагч хамрагдсан.

Судалгаанд хамрагдсан албан хаагчдаас сүүлийн 2 жилийн байдлаар 92.3% сургалтад хамрагдсан байна. Үүнээс давхардсан тоогоор ажлын байранд хийсэн сургалтад 60%, дотоодын мэргэжил дээшлүүлэх богино, дунд хугацааны сургалтад 32.3%, цахим сургалтад 69.2%, албан хаагч, гадаад улсад мэргэжил дээшлүүлэх сургалтад 17.4%, албан хаагч, магистрын сургалтад 16.9%, докторын сургалтад 4.6% эчнээ сургалтад 4.6%, бусад 12.3% нь хамрагджээ.

Ажил үүргийн хүрээнд мэдлэг, чадвараа дээшлүүлэхэд шаардлагатай байгаа сургалтын талаар албан хаагчдын өгсөн саналын нэгтгэл:

№	Бичсэн санал, сэтгэгдэл	Албан хаагчийн тоо
1.	Төрийн албаны мэргэшүүлэх багц сургалт	25
2.	Салбарын чиглэлээр олон улсын туршлага, чиг хандлага, дэвшилтэт технологи,	13
3.	Гадаад хэлний мэдлэг дээшлүүлэх	13
4.	Хууль, эрх зүйн мэдлэг, гэрээ	5
5.	Компютерийн программ хангамж	3
6.	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, албан хэрэг хөтлөлт, жендэр	3
7.	Мэргэшсэн аудитор, хяналт шинжилгээ, үнэлгээ	3
8.	Хувь хүний хөгжил	2
9.	Санхүү, худалдан авах ажиллагаа	2
	Нийт (давхардсан тоогоор)	69

Судалгааны дүнгээс үзэхэд төрийн албан хаагчдад хэрэгцээ шаардлагатай байгаа сургалтын чиглэлүүд тодорхойлогдсон бөгөөд дээрх хэрэгцээтэй уялдуулан сургалтын хөтөлбөр боловсруулах бодит шаардлага үүсч байна.

1.2. Хамрах хүрээ:

Хөтөлбөрт Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны төрийн албан хаагчид хамрагдана.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

1.1.1. Төрийн албаны тухай хуульд нийцүүлэн төрийн албан хаагчдыг үе шаттай сургаж, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ мэргэжлийн түвшинд, оновчтой, үр дүнтэй гүйцэтгэх мэдлэг ур чадварыг нь дээшлүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

1.2. Хөтөлбөрийн зорилтууд нь:

1.2.1. Төрийн албаны мэргэшүүлэх багц сургалтад албан хаагчдыг үе шаттай суралцуулах;

1.2.2. Шинээр томилогдсон залуу албан хаагчдад төрийн албаны ёс зүй, үнэт зүйлийг таниулах, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь зөвлөх, чиглүүлэх сургалт хийж хэвшүүлэх;

1.2.3. Суралцагч байгууллагын соёлыг төлөвшүүлэх;

1.2.4. Дотооддоо суралцах сургалтын орчин нөхцөл, техник хэрэгслийг сайжруулах;

1.2.5. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн, шалгуур үзүүлэлтийг тодорхойлох;

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТУУДЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА:

3.1. Төрийн албаны мэргэшүүлэх багц сургалтад албан хаагчдыг үе шаттай суралцуулах зорилтын хүрээнд:

3.1.1 Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Удирдлагын академийн төлөвлөгөөт сургалтад 1 улиралд 5 албан хаагчийг суралцуулах.

3.1.2 Мэргэшүүлэх багц сургалтад 10 албан хаагчийг суралцуулах;

3.1.3 Богино хугацааны зорилтод сургалтад 15 албан хаагчийг суралцуулах.

3.2. Шинээр томилогдсон залуу албан хаагчдад төрийн албаны ёс зүй, үнэт зүйлийг таниулах, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь зөвлөх, чиглүүлэх сургалт хийж хэвшүүлэх зорилтын хүрээнд:

3.2.1. Төрийн албанд шинээр томилогдсон залуу албан хаагчдыг дагалдан суралцуулах сургалтын төлөвлөгөө, гарын авлага боловсруулж, хэрэгжүүлэх.

3.3. Суралцагч байгууллагын соёлыг төлөвшүүлэх зорилтын хүрээнд:

3.3.1. Байгууллага дотроо суралцах боломжийг ашиглан сургалт, мэдээллийн цаг зохион байгуулж, нийт албан хаагчдыг хамруулах;

3.3.2. Төрийн албан хаагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлж, шинээр батлагдсан хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, дүрэм, журмын талаар тухай бүр мэдээлэл өгөх;

3.3.3. Монгол бичиг, гадаад хэл болон компьютерийн шинэ программын сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран шат дараатай зохион байгуулах;

3.3.4. Төрийн албан хаагчийг бие дааж суралцах боломж нөхцөлөөр хангаж, дэмжих.

3.4. Дотооддоо суралцах сургалтын орчин нөхцөл, техник хэрэгслийг сайжруулах зорилтын хүрээнд:

3.4.1. Сургалтын техник, тоног төхөөрөмж бүхий танхим тохижуулах;

3.4.2. Төрийн албан хаагчдад зайн сургалтад суралцах мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх;

3.4.3. Ажлын байранд цахим сургалт, мэдээлэл хүлээн авах хүртээмжийг сайжруулах.

3.5. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн, шалгуур үзүүлэлтийг тодорхойлох зорилтын хүрээнд:

3.5.1. Сургалтын хөтөлбөрийн үр дүнг гүйцэтгэлийн чанартай уялдуулж үнэлнэ.

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА:

4.1. Хөтөлбөрийг 2023-2027 онд хэрэгжүүлнэ.

-Нэг дэх үе шат (2023-2025): хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх;

-Хоёр дахь үе шат (2025-2027): хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үр дүнг үнэлэх;

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ САНХҮҮЖИЛТ:

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтыг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ.

5.1.1. Улсын төсөв;

5.1.2. Яамны жил бүрийн төсөв;

5.1.3. Олон улсын байгууллага, хандивлагч орнуудын буцалтгүй тусламж, төслийн санхүүжилт;

5.1.4. Бусад эх үүсвэр.

5.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсвийн төсөлд тусган батлуулж, санхүүжүүлнэ.

ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ:

6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг Төрийн захиргааны удирдлагын газар хариуцна.

6.1.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр батлаж, хэрэгжилтийг зохион байгуулна.

6.1.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор гаргаж, дотоод сүлжээнд байршуулна.

6.2. Хөтөлбөрийн хэрэгжилтэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

ДОЛОО. ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

7.1. Төрийн албан хаагчийн мэдлэг чадвар дээшилж, мэргэшиж, хөгжсөнөөр салбарын бодлогыг оновчтой тодорхойлж, яамны үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн дээшилж, иргэндээ үйлчилдэг, мэргэшсэн, чадварлаг, ил тод, үр нөлөөтэй төрийн алба төлөвшинэ.

НАЙМ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРЧИМ, ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА:

8.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчим баримтлана:

8.1.1. Ил тод нээлттэй байх;

8.1.2. Тэгш, хүртээмжтэй байх;

8.1.3. Үр дүнд чиглэсэн байх;

8.1.4. Хамтын ажиллагаанд тулгуурлах.

8.2. Хөтөлбөр нь дараах байгууллагуудтай хамтын ажиллагааны үр дүнд хэрэгжинэ.

8.2.1. Засгийн газрын хэрэг эрхлэх газар;

8.2.2. Төрийн албаны зөвлөл;

8.2.3. Удирдлагын академи;

8.2.4. Олон Улсын хамтын ажиллагааны байгууллагууд;

8.2.5. Гадаад, дотоодын их, дээд сургуулиуд.

ЕС. БУСАД:

8.1 Хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар яамны удирдлага, албан хаагчид тодорхой санал хүсэлт гаргаж болох ба хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүн, албан хаагчдын санал хүсэлтийг үндэслэн хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.